



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Цусаа бэлэглэх өдрийг  
бий болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2007 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, цусны донорын үйлсийг сурталчлах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2015 оны 04 дүгээр сараас эхлэн сар бүрийн 03-ны өдрийг “Цусаа бэлэглэх өдөр” болгон салбарын хэмжээнд зохион байгуулсугай.


2. Донорын эгнээг өргөжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог сайжруулах, донорын үйлсийг сурталчлах, алдаршуулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт даалгасугай.

3. Цусаа бэлэглэх өдрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааг мэргэжил аргазүйгээр хангаж, халдвар хамгааллын дэглэм, цусны аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/-д, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Цаашид тус өдрийг үндэсний хэмжээний тэмдэглэлт өдөр болгон зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дарга /Н.Эрдэнэбаяр/-д даалгасугай

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080420